

ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2026

ГАЗАРЗҮЙ

II. Сонгох даалгавраас зөвхөн нэг хариу сонгоорой.

1. Нарнаас хамгийн хол зайд орших гараг аль нь вэ? /1оноо/
- A. Далай ван
 - B. Сугар
 - C. Ангараг
 - D. Тэнгэрийн ван
 - E. Санчир
2. Хүн амын тоог нутаг дэвсгэрт нь харьцуулсан харьцааг гэнэ. /1оноо/
- A. Хүн амын байршил
 - B. Хүн амын шилжилт
 - C. Хүн амын нягтшил
 - D. Хүн амын нутагшилт
 - E. Хүн амын өсөлт
3. Магмын гаралтай чулуулаг аль нь вэ? /1оноо/
- A. Хөрзөн чулуу
 - B. Боржин чулуу
 - C. Шохойн чулуу
 - D. Гнейс
 - E. Доломит
4. Тухайн газар нутагтаа улс төр, нийгэм эдийн засаг, хүн амын тоо, дэд бүтцийн харилцааны хувьд чадамж өндөртэй хот нь ойролцоох жижиг хотуудтайгаа нийлж бөөгнөрөл үүсэх үйл явцыг АГЛОМЕРАЦ гэнэ. Дараах агломерацуудаас хамгийн олон хүн амтай хот аль нь вэ? /1оноо/
- A. Рейкьявик
 - B. Сантьяго
 - C. Гавана
 - D. Нью-Йорк
 - E. Абу-Даби
5. Үдийн нарны эгц тусгал жилд 2 удаа тохиох газрыг сонгоно уу? /1оноо/
- A. Мэлхийн зам
 - B. Туйл
 - C. Матрын зам
 - D. Туйлын цагираг
 - E. Экватор
6. Машины үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээс тээврийн төрөлд хамаарахыг сонгоно уу? /1оноо/
- A. Мотоцикл
 - B. Радио
 - C. Каран
 - D. Компьютер
 - E. Телевизор




Явцын үнэлгээ

Хувилбар: С

7. Газарзүйн бүрхэвчийн физик газарзүйн цогцолборыг ангилсан бүдүүвчинд тохирох хариулт аль нь вэ? /1оноо/



- A. Элсэн манхан цогцолбор
 - B. Хээрийн цогцолбор
 - C. Шүрийн цогцолбор
 - D. Уулархаг нутгийн цогцолбор
 - E. Голын хөндийн цогцолбор
8. Аль нь улс төрийн даяаршлын хүрээнд хамаарагдах вэ? /1оноо/
- A. Экспорт, импорт
 - B. Чөлөөт худалдаа
 - C. Элчин сайдын яам
 - D. Сонин сэтгүүл
 - E. Театр
9. Монгол орны дундад өргөргийн уулын босоо бүслүүрийн зурагт 1-ийн тоогоор ямар бүслүүрийг тэмдэглэсэн бэ? /1оноо/



- A. Хээрийн
 - B. Тагийн
 - C. Мөнх цасны
 - D. Тайгын
 - E. Ойт хээрийн
10. Ардчиллын индексийг хэмжих үндсэн хэмжигдэхүүнийг олно уу? /1оноо/
- A. Эрүүл мэндийн байдал
 - B. Нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээ
 - C. Төрөлт, нас баралт
 - D. Шударга ёс
 - E. Эдийн засгийн бүтэц, гол салбарууд

11. Нэгэн төрлийн орчинд орших ургамал, амьтан, бичил биетний харилцан холбооны нэгдлийг гэнэ. /1оноо/

- A. Экоотоп
- B. Экосистем
- C. Биотоп
- D. Микроценоз
- E. Биоценоз

12. Газарзүйн зургийн үндсэн тусгагийн төрлөөс алийг нь дүрсэлсэн байна вэ? /1оноо/






- A. Конус тусгаг
- B. Синусоид тусгаг
- C. Гүүдийн тусгаг
- D. Цилиндр тусгаг
- E. Меркаторын тусгаг

13. Дангаарчлалын үзэл санааг оновчтой илэрхийлсэн үйл ажиллагааг сонгоно уу? /1оноо/

- A. Дэлхийн банк
- B. Олимп
- C. Цагаан сар
- D. Аутсорсинг
- E. Европын холбоо

14. Хүн амын суваргануудаас ХӨГШИН бүтэцтэй нь аль вэ? /1оноо/



15. Австралийн хамгийн олон хоньтой муж улсыг сонгоно уу? /1оноо/



- A. Баруун Австрали
- B. Шинэ Өмнөд Уэльс
- C. Виктори
- D. Өмнөд Австрали
- E. Квинсленд

16. Номхон далай, Атлантын далайг холбосон усан зам бүхий сувгийг олоорой? /1оноо/

- A. Цагаан тэнгисийн суваг
- B. Килийн суваг
- C. Ханберийн суваг
- D. Панамын суваг
- E. Суэцийн суваг


17. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан хөрсийг хамгаалах, нөхөн сэргээхийн тулд хүний үйл ажиллагаануудаас хамгийн тохиромжтойг нь сонгоно уу. /1оноо/

- A. Газар тариаланд төрөл бүрийн химийн бордоо хэрэглэх
- B. Лаазалсан бүтээгдэхүүнийг хэрэглэх
- C. Малын тоо толгойг нэмэгдүүлэх
- D. Шороон зам олшрох
- E. Давуун уут хэрэглэх

18. Африк тивийн хамгийн өндөр цэг Килиманджаро нь д.т.д 5895 м, хамгийн нам цэг нь Ассаль нуур нь д.т.д -153 м бол уг тивийн гадаргын өндрийн зөрүү хэд вэ? /1оноо/

- A. 6048 м
- B. 5742 м
- C. 38 м
- D. 3024 м
- E. 2871 м

19. Усны хэт их хэрэглээний улмаас цэвэр усны нийлүүлэлтийн хомсдолд хамгийн их өртөж буй улс аль нь вэ? /1оноо/




- А. Парагвай В. Конго С. ОХУ
 Д. Австрали Е. Тайланд

20. Дэлхийн гадаргын хэлбэр өөрчлөгдөхөд нөлөөлөх дотоод хүчин зүйлийг сонгоно уу? /1оноо/

- А. Усны урсгал
 В. Салхи
 С. Хавтангийн хөдөлгөөн
 Д. Нарны энерги
 Е. Хур тунадас

21. Далайн ёроолын хотгор гүдгэрийг харуулсан зурагт "З" үсгээр тэмдэглэсэн гадаргын элементийг нэрлэнэ үү? /1оноо/



- А. Эх газрын хажуу
 В. Шельф
 С. Далайн гүн хонхор
 Д. Далайн ёроолын тал
 Е. Галт уулын арал

22. Голоос авсан дээж чулуулгийн элэгдлийн зэргийг тодорхойлно уу? /1оноо/




- А. Бага зэргийн өнцөгтэй
 В. Мөлгөр
 С. Маш арзгар
 Д. Бага зэргийн мөлгөр
 Е. Мөлгөрдүү

23. Алтайн өвөр говийн нутгаар ургадаг цөлийн экосистемийн гол төлөөлөгч ургамлыг сонгоно уу? /1оноо/

- А. Вансэмбэрүү
 В. Таван салаа
 С. Нэрс
 Д. Ерхөг
 Е. Заг

24. Хөрсний зүсэлтийн зурагт В үсгээр аль давхаргыг тэмдэглэсэн байна вэ? /1оноо/




- А. Хучаас үе
 В. Суурь чулуулгийн үе
 С. Хуримтлалын үе
 Д. Ялзмагийн үе
 Е. Ургамлын үе

25. Дэлхийн экватораараа цүлхэгэр хэлбэртэй болоход нөлөөлсөн хүчин зүйл аль нь вэ? /2оноо/

- А. Дэлхийн дотоод гүний энерги экваторт хамгийн их
 В. Тэнхлэгээ эргэх хурд экваторт хамгийн их
 С. Нарны энерги экваторт хамгийн бага
 Д. Кориолисийн хүч экваторт хамгийн бага
 Е. Төвөөс зугатаах хүч экваторт хамгийн бага

26. Цаг агаарын зурагт ижил даралттай шугамыг уншаад салхи аль зүг рүү чиглэж байгааг олоорой? /2оноо/



- A. Баруунаас зүүн
- B. Өмнөдөөс хойд
- C. Хойноос өмнөд
- D. Зүүнээс баруун
- E. Зүүн өмнөдөөс баруун хойд

27. Газар дундын тэнгис дэх Мальта улсад 1000 хүн тутам дахь төрөлт 10.3%, нас баралт 8.3% бол тухайн улсын хүн амын ердийн өсөлт хэд вэ? /2оноо/

- A. -2%
- B. 18.6%
- C. 0.002%
- D. 2%
- E. 85.4%

28. Антарктидад хүн ам маш бага тархан суурьшсан шалтгааныг сонгоно уу? /2оноо/

- A. Жилд унах хур тунадас нь 2000мм-ээс дээш нутаг
- B. Хамгийн дулаан сарын температур нь +20°C-аас дээш нутаг
- C. Хөрсний бүтэц сайн, эрдэс бодисоор элбэг нутаг
- D. Гадаргын өндөр нь д.т.д 6000м-ээс дээш өндөртэй нутаг
- E. Далайн хүйтэн урсгалын нөлөөнд оршдог нутаг

29. Үүлнээс буудаг тунадасны хэлбэрүүдийг олоорой. /2оноо/

- A. Цас, шиврээ бороо, мөндөр
- B. Манан, мөндөр, аадар бороо
- C. Аадар бороо, шүүдэр, будан
- D. Униар, цас, манан
- E. Шиврээ бороо, будан, униар


30. Аль нь эсрэг циклоны шинж вэ? /2оноо/

- A. Төвдөө бага даралттай
- B. Тэнгэр бүрхэг
- C. Салхи шуургатай
- D. Хур тунадас орохгүй
- E. Агаарын хөөрөх хөдөлгөөн

31. Улс орны тогтвортой хөгжлийг хангахад зориулагдсан "ЭКО аялал жуулчлал"-ын хөтөлбөрийг сонгоно уу? /2оноо/

- A. Загасчлах аялал – Өвлийн улиралд голын усанд цооног үүсгэн загас барих
- B. Спорт аялал – Спорт машинаар уралдах
- C. Ангийн аялал – Ховордсон ан амьтдыг агнах
- D. Завьтай аялал – Тэнгисийн гүнд шумбаж далайн гүнээс шүр, сувд, хясаа түүх
- E. Явган аялал – Жимс, жимсгэний тариан талбайн дундуур явж судлах


32. ГМС-ийн өгөгдлийг растер дүрслэлээр зөв зурсаныг сонгоно уу? /2оноо/



33. Хүн амын дундаж наслалт нь 81.6 жил, нэг хүнд ногдох ДНБ нь 70392 ам.доллар, нийгмийн баялагийн тэгш хуваарилалтын сонгодог жишээ болсон энэхүү өндөр хөгжилтэй орныг сонгоно уу? /2оноо/

- A. Бразил
- B. Мексик
- C. Индонези
- D. Норвеги
- E. Энэтхэг

34. Төрөлт, нас баралтын түвшин өндөр, хүн амын өсөлт бага байдаг. Хүн ам зүйн шилжилтийн I үе шатанд тохирох улсыг сонгоно уу. /2оноо/



- A. Хятад
- B. Бразил
- C. Австрали
- D. ОХУ
- E. Судан

35. Өрхийн аж ахуй эрхлэлтийн үйл ажиллагааны шинжүүдээс оновчтой зөв тодорхойлолтыг сонгоно уу? /2оноо/

1. Маш бага талбайд аж ахуй эрхэлдэг
2. Ур чадвартай, цалинтай хөдөлмөр эрхлэгсэд байдаг
3. Их хэмжээний орцын хөрөнгө оруулалт шаардлагатай
4. Бордоо бага ашигладаг, өтөг зэргийг ашигладаг

- A. 1; 4
- B. 2; 3
- C. 3; 4
- D. 1; 3
- E. 2; 4

36. 1000гр далайн усанд агуулагдах Хлорт магни ($MgCl_2$) нь 14.2%-ийг бол давсны хэмжээ хэдэн грамм байхыг тооцоолж олоорой. /2оноо/

- A. 70.42 гр
- B. 142 гр
- C. 4.97 гр
- D. 40.57 гр
- E. 3.52 гр

37. Байрзүйн зургийн нэрлэлийг масштабтай нь зөв харгалзуулсаныг олоорой. /2оноо/


- | | |
|-------------|--------------|
| 1. K-48-A | a. 1:300000 |
| 2. K-48 | b. 1:100000 |
| 3. K-48-144 | c. 1:500000 |
| 4. III-K-48 | d. 1:1000000 |
- A. 1b, 2c, 3d, 4a
 - B. 1c, 2d, 3b, 4a
 - C. 1c, 2d, 3a, 4b
 - D. 1b, 2d, 3a, 4c
 - E. 1d, 2c, 3b, 4a

38. Агаарын чанарын индексийн үзүүлэлт, ангилалыг эрүүл мэндэд үзүүлэх нөлөөтэй нь зөв харгалзуулна уу? /2оноо/

Агаарын чанарын индекс	Агаарын чанарын ангилал	Эрүүл мэндэд үзүүлэх нөлөө
1. 401 - 500	A. Дунд зэргийн бохирдолтой	a. Агаарын чанарын шаардлага хангадаг нөлөөлөлд өртдөг
2. 51 - 100	B. Хэвийн	b. Удаан хугацаагаар гадаа байхад нийт хүн амын эрүүл мэндэд мэдрэгдэхүйц сөрөг нөлөө илэрнэ
3. 251 - 400	C. Их бохирдолтой	c. Нийт хүн амын эрүүл мэндэд бага зэрэг сөрөг нөлөө үзүүлнэ

- A. 1Cc, 2Aa, 3Bb
- B. 1Ac, 2Ba, 3Cb
- C. 1Bc, 2Cb, 3Aa
- D. 1Cb, 2Ba, 3Ac
- E. 1Aa, 2Bb, 3Cc

39. Туул голын сав газрын зургийг ажиглан усны бохирдол нь МАШ БОХИР үзүүлэлттэй газар нутгийг олно уу. /2оноо/



- A. Орхонтуул сум B. Рашаант сум C. Тэрэлж
D. Налайх E. Алтанбулаг сум



“Галт уулын дэлбэрэлтийн улмаас тосгонд хөрс, агаарын бохирдол үүссэн тул нутгийн удирдлагууд оршин суугчдыг нүүлгэх шийдвэр гаргасан нь иргэдийн хүчтэй эсэргүүцэлтэй тулгарав. Учир нь маш олон эерэг нөлөө байдаг тухай тэд ярьж тайлбарладаг.”

Чили улсын Чайтэн галт уул дэлбэрсэний дараах байдал

Өгөгдлөөс нүүлгэн шилжүүлэлт хийх зайлшгүй шалтгааныг нь олоорой. /2оноо/


- A. Үнс тоос, утаа ихтэй, агаар нь бохир учир хүмүүс маск зүүдэг
B. Эдийн засгийн үр жилээс жилд өгөөж нэмэгддэг
C. Жимс, самрын аж ахуй ихээр хөгждөг
D. Жуулчдыг татах амралт, рекреацийн нөөц бий болдог
E. Гейзер халуун булгийн усыг ашиглан дулааны шугамандаа ашигладаг



41. Франц улс нь Приней хойгийг тойрох 2800 км урт замыг дөтлөхийн тулд Газар дундын тэнгисээс Бискайн булан руу 400 орчим км шулуун зам барив. Тухайн үед үүссэн ҮНЭМЛЭХҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ бүхий байгалийн саадыг шийдвэрлэсэн арга замыг сонгоорой. /2оноо/

- A. Тунель гаргах
B. Далан барих
C. Даваа сэтлэх
D. Суваг татах
E. Гүүр тавих

42. Дэлхий нарыг тойрох орбитын замын зургийг ажиглан J байрлал дахь дэлхий дээр хэддүгээр сар болж байгаа вэ? /2оноо/



- A. 7-р сар
B. 3-р сар
C. 1-р сар
D. 11-р сар
E. 8-р сар

43. Манай орны олон улсын шууд нислэгтэй АЛЬФА ХОТ аль нь вэ? /2оноо/

- A. Канберра
B. Токио
C. Рио-де-Жанейро
D. Канзас
E. Берлин

44. Ангараг гарагийн нарнаас алслагдсан зайг Боде-ийн хуулийн томьёо ашиглан одон орны нэгжээр тооцоолж олоорой. /2оноо/

$$L = \frac{G + 4}{10}$$

L – Гарагийн нарнаас алслагдсан зай одон орны нэгжээр

(1о.о.н=150сая км)

G – Тухайн гараг өмнөх гарагаас 2 дахин их зайд байрлах дараалал (геометр прогресс)

- A. 0.8 о.о.н
B. 1.3 о.о.н
C. 0.4 о.о.н
D. 1.6 о.о.н
E. 2 о.о.н

45. Суурин газрын шатлалын хэлбэрийг хөдөөгөөс хот руу зөв эрэмбэлж бичсэнийг олоорой. /2оноо/



- A. Хот, жижиг хот, гацаа, тосгон, аварга хот, том хот
B. Тосгон, гацаа, хот, жижиг хот, аварга хот, том хот
C. Аварга хот, том хот, хот, жижиг хот, тосгон, гацаа
D. Гацаа, жижиг хот, тосгон, аварга хот, хот, том хот
E. Гацаа, тосгон, жижиг хот, хот, том хот, аварга хот


46. АНУ-ын 3 бүсийн мэдээллийн технологийн салбарт ажиллагсдын тоог харуулсан графикийг ажиглан цэгийн оронд тохирох хариултыг сонгоорой. /2оноо/



..... бүсийн мэдээллийн технологийн салбарт ажиллагсдын хувь оны хооронд огцом өссөн байна.

- A. Цахиурын хөндий, 1998-2000
- B. Лос Анжелес, 2000-2002
- C. Сиэтл, 1990-1992
- D. Цахиурын хөндий, 1996-1998
- E. Сиэтл, 2002-2004

47. Зураг 1-ийг ажиглан Меркаллын шатлалаар газар хөдлөлтийн хүч, балл ямар болохыг тодорхойлно уу. /2оноо/



- A. Газар хөдлөлт их хүчтэй, VIII балл
- B. Газар хөдлөлт хүчтэй, VI балл
- C. Газар хөдлөлт маш хүчтэй, XII балл
- D. Газар хөдлөлт хүч багатай, IV балл
- E. Газар хөдлөлт маш их хүчтэй, X балл


48. Гангийн үйлдвэрийн үйл явцын зөв дарааллыг сонгоорой. /2оноо/



49. +15° температуртай агаарын харьцангуй чийг 31.19%, үнэмлэхүй чийгийн багтаамж нь 13.37 г/м³, үнэмлэхүй чийгийн хэмжээ нь 4.17 г/м³ бол дутмаг чийгийг тооцоолж олоорой. /2оноо/

- A. 10.8 г/м³
- B. 17.8 г/м³
- C. 27 г/м³
- D. 1.6 г/м³
- E. 9.2 г/м³

50. ГУРВАЛЖИН ДИАГРАММЫГ ашиглан P үсгээр тэмдэглэсэн цэг дээрх хөрсний бүтцийг тодорхойлон ямар хөрс болохыг нэрлээрэй. /2оноо/



Хөрсний хэсгүүдийн бүтцийг харуулсан диаграмм


- A. Элс-80%, шавар-10%, тоос-10%, Нарийн элсэн хөрс
- B. Элс-90%, шавар-20%, тоос-10% Элсэнцэр хөрс
- C. Элс-70%, шавар-20%, тоос-10% Шавранцар хөрс
- D. Элс-10%, шавар-10%, тоос-80% Хөнгөн шавранцар хөрс
- E. Элс-20%, шавар-10%, тоос-70% Элсэрхэг шавар хөрс

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж:

- Энэ хэсэг сонгох даалгавар биш тул бодолтыг зөв олж тогтоож, хариуг бөглөөрэй.
- Хоёрдугаар хэсгийн бодлогын хариуг хариултын хуудасны хоёрдугаар хэсэгт доорх хэлбэрээр бөглөхийг анхаарна уу. Жишээлбэл: Бодлогын хариу 123456 гарсан гэж үзвэл [a1 b2 c3 d4 e5 f6] гэж бөглөнө.
- Хэрэв бодлогын хариу бутархай тоо байвал бодлого тус бүрийн хариултын загварын дагуу бөглөнө. Жишээ нь: Бодлогын хариу 1.3 гарсан гэж үзвэл тухайн бодлогын хариулт бөглөх загварыг [a.b] гэсэн байдлаар өгсөн байна. Дээрх хариуг бөглөхдөө [a1 b3] гэж бөглөнө.
- Бодлогын хариуг тооцоолж гарган ажиглаад тухайн зүйлийн нэрийг зөв олж тохирох хувилбарыг [c] эгнээнд тэмдэглэнэ. Жишээ нь: 2 дугаартай элс гэж үзвэл [c2] гэнэ.

2.1. Ханбогд хот ЗУ107°, ХӨ43°, Гурвантэс сум ЗУ102°, ХӨ43°-д оршдог бол хотуудын хоорондох зайг олоорой. /ХӨ43°-ын уртрагийн 1°-д тулах зэргэдийн нумын урт нь 81.4км/



- а. Уртрагийн зөрүүг тооцоолох [a] /2оноо/
- б. Хот хоорондын зайг олох [bcd] /4оноо/

2.2. Өвөрхангай аймаг нь 2016 оны байдлаар 112000 хүн амтай, хүн амын жилийн дундаж өсөлт нь 1.5% байв. 40 жилийн дараа буюу 2056 он гэхэд Өвөрхангай аймгийн хүн амын тоо ойролцоогоор хэд болохыг тооцоолоорой. [abcdef] /6оноо/

$P_n = P_0(1 + (R/100)T)$

P_0 - тухайн жилийн хүн амын тоо
 R - жилийн дундаж өсөлт
 T - Тооцоонд хамаарах жилийн тоо

2.3. Сэрүүн бүслүүрт гадаргад ирж буй нийт цацрагийн хэмжээ 80ккал/см², ойсон цацрагийн хэмжээ 8ккал/см² байсан бол гадаргын ойлгох чадвар (альбедо)-ыг хувиар тооцоолно уу. Гарсан хариуг ажиглан ямар гадаргуу болохыг нэрлээрэй.

$$A = \frac{R}{Q} 100\%$$

- А. Альбедог тооцоолох [ab] /4оноо/
- Б. Гадаргууг нэрлэх [c] /2оноо/
- Хар зам
 - Мөстлөг
 - Ой мод
 - Элс
 - Үүл

2.4. Бангладеш улсын нутаг дэвсгэрийн талбай нь 144000км², голуудын нийт урт нь 172800км бол тухайн улсын гол мөрдийн сүлжээний дундаж нягтшилыг тооцоолон ямар гол болохыг нэрлээрэй.

$$H = \frac{L}{S}$$

- а. Голын нягтшил тооцоолох [a.b] /4оноо/
- б. Голыг нэрлэх [c] /2оноо/
- Енисей мөрөн
 - Брахмапутра
 - Замбези
 - Ижил мөрөн
 - Маккензи

№	Зөв хариу	Оноо
1	A	1
2	C	1
3	B	1
4	D	1
5	E	1
6	A	1
7	D	1
8	C	1
9	B	1
10	D	1
11	E	1
12	A	1
13	C	1
14	D	1
15	B	1
16	D	1
17	E	1
18	A	1
19	D	1
20	C	1
21	E	1
22	C	1
23	E	1
24	C	1
25	B	2
26	A	2
27	D	2
28	E	2
29	A	2
30	D	2

№	Зөв хариу	Оноо
31	E	2
32	A	2
33	D	2
34	E	2
35	A	2
36	C	2
37	B	2
38	D	2
39	E	2
40	A	2
41	D	2
42	C	2
43	B	2
44	D	2
45	E	2
46	A	2
47	D	2
48	C	2
49	E	2
50	A	2
2.1	a-5	4
	bcd-407	2
2.2	abcdef-179200	6
2.3	ab-10	4
	c-1	2
2.4	a.b-1.2	4
	c-2	2